

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН  
ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ЗАРИМ ЗҮЙЛ ЗААЛТЫН  
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ  
ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**Улаанбаатар  
2025**

## ГАРЧИГ

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ</b>	<b>3</b>
<b>ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ</b>	<b>4</b>
<b>ГРАФИКИЙН ЖАГСААЛТ</b>	<b>5</b>
<b>УДИРТГАЛ</b>	<b>6</b>
<b>НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ</b>	<b>7</b>
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	7
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	8
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	8
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох	11
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	12
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	12
<b>ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ</b>	<b>13</b>
<b>ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ</b>	<b>14</b>
<b>3.1. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал</b>	<b>14</b>
3.1.1. НӨАТ-ын босго дүн /НӨАТтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2/	14
3.1.2. НӨАТ-ийн борлуулалтын орлогын суурь /НӨАТтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1,10.2.2/	17
3.1.3. НӨАТ-ийн чөлөөлөлт /13 дугаар зүйлийн 13.1.7, 13.1.15, 13.1.16, 13.1.17, 13.1.18, 13.1.20, 13.1.24, 13.1.28, 13.1.29 13.6/	20
3.1.4. НӨАТ-аас хасалт хийх /НӨАТтХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.4, 14.1.5/	23
<b>3.2. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал</b>	<b>26</b>
3.2.1.Хэлэлцүүлгээс ирүүлсэн санал	26
3.2.2.Цахимаар ирүүлсэн санал	34
<b>ДҮГНЭЛТ, САНАЛ</b>	<b>35</b>
<b>АШИГЛАСАН МАТЕРИАЛ</b>	<b>37</b>
<b>ХАВСРАЛТ</b>	<b>38</b>

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

НӨАТХ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ААН	Аж ахуйн нэгж
ТЕГ	Татварын ерөнхий газар
МҮХАҮТ	Монголын Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд,

Хүснэгт 2. Хүснэгт 2. “Үнэлгээний харьцуулах хэлбэрийн тайлбар”,

Хүснэгт 3. “Практик нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн зүйл, заалт,

Хүснэгт 4. “НӨАТ-ын босго дүнтэй холбоотой олон нийт, ААН-ээс ирүүлсэн саналын нэгтгэл,

Хүснэгт 5. “Практик нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн зүйл, заалт,

Хүснэгт 6. “Практик нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн зүйл, заалт,

Хүснэгт 7. НӨАТ-ийн чөлөөлт эдэлсэн байдал 13 дугаар зүйлийн 13.1.13-13.5.3,

Хүснэгт 8.НӨАТ-ийн чөлөөлт эдэлсэн байдал 13 дугаар зүйлийн 13.5.13-13.5.4,

Хүснэгт 9. НӨАТ-ийн чөлөөлт эдэлсэн байдал 13 дугаар зүйлийн 13.1.8- 13.1.25,

Хүснэгт 10.НӨАТ-аас чөлөөлөх, бараа, ажил үйлчилгээтэй холбоотой албан бичгээр ирсэн саналын нэгтгэл,

Хүснэгт 11. “Практик нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн зүйл, заалт,

Хүснэгт 12. Барилга байгууламж, тоног төхөөрөмжөөс хувь тэнцүүлэн хасалт хийсэн дүн мэдээ 2020-2024,

Хүснэгт 13. “Иргэд олон нийтээс НӨАТ холбогдуулан олон давтамжтай ирүүлсэн саналын нэгтгэл,

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

*График 1. “Татварын хуулийн шинэчлэл” судалгаанд оролцсон татвар төлөгчийн мэдээлэл,*

*График 2. “Татварын хуулийн шинэчлэл” судалгаагаар НӨАТ-ын босго хэмжээнд ирүүлсэн санал,*

*График 3. “Татварын хуулийн шинэчлэл” судалгаагаар НӨАТ-ын борлуулалтын орлогын мөнгөн суурийн хүрээнд ирүүлсэн санал,*

*График 4. “Татварын хуулийн шинэчлэл” судалгаагаар НӨАТ-ын хувь тэнцүүлэн хасах хийх зохицуулалтын хүрээнд ирүүлсэн санал,*

*График 5. “Татварын хуулийн шинэчлэл” судалгаагаар НӨАТ-ын хувь хэмжээ, зохицуулалттай холбоотой ирүүлсэн санал,*

\

## УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны Үйл ажиллагааны хөтөлбөр”-т татвартай холбоотой 17 чиглэл тусгагдсан. Үүнийг 8 чиглэл нь 3.2.1-д заасан Татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийн хүрээнд тусгагдсан. Харин үлдсэн 9 чиглэл нь Шилжилт хөдөлгөөн (1.4.1.7), Хөдөлмөр эрхлэлт (2.1.2.10), Нийгмийн баталгаа (2.1.3.11), Банк, санхүү, даатгалын салбарын шинэчлэл (3.1.3.5), Бизнес, хөрөнгө оруулалтын таатай орчин (3.2.2.8, 3.2.2.11), Шинжлэх ухаан, технологи, инновац (3.3.7.4), Ногоон эдийн засаг, ногоон хөгжлийн загвар (3.4.3.9), Сансар судлал, харилцаа холбоо, мэдээлэл технологи (4.3.2.3)-ийг салбарт татварын шинэчлэл хийхэд хамаарч байна.<sup>1</sup> Эдгээр татварын шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлэх зайлшгүй шаардлагатай. Ингэснээр татварын хуулийн хэрэгжилтийн бодит байдал дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх юм.

Иймд Татварын Ерөнхий газрын зүгээс “Татварын Ерөнхий хууль”, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”, “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”, “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”, “Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хууль”-ийн зарим зүйл заалтад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийлээ.

Энэхүү тайлангаар Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /цаашид “НӨАТХ” гэх/-ийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэллээ. Тодруулбал, Монгол Улсын Их Хурлаас Татварын Ерөнхий хуулийг 2015 онд баталж, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн<sup>2</sup> бөгөөд хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлээд 9 жилийн хугацаа өнгөрч байна.

НӨАТХ-ийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан үнэлгээ хийж, судалгааны тайланг боловсруулсан.<sup>3</sup>

---

<sup>1</sup>Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 21, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны Үйл ажиллагааны хөтөлбөр, УБ, 2024, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1>

<sup>2</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, УБ, 2015, <https://legalinfo.mn/mn/detail/11227>

<sup>3</sup> Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол, Дугаар 59, Аргачлал батлах тухай, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207338&showType=1>

## НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

НӨАТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын /цаашид “Аргачлал” гэх/ дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн ба “төлөвлөх” шатанд дараах ажил хийгдэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

### 1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Үнэлгээ хийх шалтгаан нь төлөвлөлтийн үе шатны суурь хүчин зүйл бөгөөд гол төлөв тухайн хууль, эсхүл түүний зохицуулалт / бүлэг, зүйл, хэсэг заалт/-ын болохгүй байгаа болон болж байгаа талыг гаргаж ирэхэд оршино. Аливаа нэг хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хэрэгжилтийн үр дагавар, үр нөлөөг судлахад зайлшгүй тодорхой шалтгаан хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хууль нь тухайн харилцааг зохицуулж чадаж буй эсэх, түүний нийгэмд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэхийн тулд үнэлгээний ажлыг эхлэхээс өмнө үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно.<sup>4</sup>

НӨАТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлэх шалтгааныг дараах байдлаар тодорхойлж байна. Нэг талаас Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны Үйл ажиллагааны хөтөлбөр”-т татвартай холбоотой 17 чиглэл тусгагдсан. Эдгээр татварын шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлэх зайлшгүй шаардлагатай. Ингэснээр татварын хуулийн хэрэгжилтийн бодит байдал дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх юм. Уг ажлын хүрээнд Татварын Ерөнхий газрын зүгээс 7 хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаврыг үнэлж байгаа бөгөөд үүний нэг нь НӨАТХ юм.

Нөгөө талаас НӨАТХ-ийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх хуулийн хугацаа болсон. Тодруулбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-д “...хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх...” гэж хуульчилсан. НӨАТХ-ийг Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталж, 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн.<sup>5</sup>

Иймд, **Нэгдүгээрт**, Монгол Улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан татварын шинэчлэл, **Хоёрдугаарт** НӨАТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хуулийн хугацаа болсон гэсэн шалтгаанаар тус хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийг үр дагаврыг үнэллээ.

<sup>4</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”, Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, УБ, 2016, 303-304 дэх тал

<sup>5</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, УБ, 2015, <https://legalinfo.mn/mn/detail/11227>

## **1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох**

Үнэлгээний хүрээ тодорхойлох ажиллагаа нь хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэгддэг. Энэ нь үнэлгээ хийх болсон шалтгаануудтай харилцан уялдаа, хамааралтайгаар хийгдэх ажиллагаа бөгөөд тодорхойлогдсон эерэг, сөрөг нөхцөл байдал, хүндрэл бэрхшээл, тулгамдсан асуудал, үр дагавар бүхий харилцаатай холбогдсон хуулийн зохицуулалтыг илрүүлнэ. Ингэхдээ хуулийг бүхэлд нь эсхүл түүний зүйл, хэсэг, заалтыг сонгож болно.<sup>6</sup>

Өөрөөр хэлбэл, үнэлгээний хүрээг тогтоох нь тухайн хуулийн хэрэгжилтэд хамгийн их нөлөөлөл /эерэг болон сөрөг/ үзүүлж буй хэм хэмжээг тусгаарлан сонгох ажиллагаа бөгөөд эдгээрийг хэр оновчтой сонгохоос судалгааны чанар ихээхэн хамаардаг.

Энэхүү судалгаагаар НӨАТтХ-ийн хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг сонгож, үнэлгээ хийх хүрээг тус хуулийн дараах зүйл заалтуудаар тогтоов. Үүнд:

1. НӨАТ-ын босго дүн /НӨАТтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2 дугаар зүйлийн 6.5/
2. НӨАТ-ийн борлуулалтын орлогын суурь /НӨАТтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 10 дугаар зүйлийн 10.2.2/
3. НӨАТ-ийн чөлөөлөлт /НӨАТтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.7, 13.1.15, 13.1.16, 13.1.17, 13.1.18, 13.1.20, 13.1.24, 13.1.28, 13.1.29, 13.6/
4. НӨАТ-аас хасалт хийх /НӨАТтХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.5/

## **1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох**

Үнэлгээг хэмжих багаж, хэрэгсэлгүйгээр тухайн асуудал хэрхэн, яаж өөрчлөгдсөн, одоо ямар байгааг мэдэх боломжгүй юм. Иймд шалгуур үзүүлэлт бүр хуулийн хэрэгжилтийн бодит байдлыг тодорхойлоход чиглэсэн. Шалгуур үзүүлэлтийг тогтоох, сонгохын тулд тэдгээрийн тус бүрийн ойлголт, хоорондын ялгаа, онцлогийг харгалзан үзэх нь чухал юм. Сонгосон шалгуур үзүүлэлт нь тухайн зохицуулалтын хэрэгжилтийг шалгаж чадах, тэдгээрийн хэмжих боломжтой байх ёстой гэдгийг анхаарах нь зүйтэй.<sup>7</sup>

Иймд, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу ТЭХ-ийн зарим зүйл заалтын хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. “Практикт нийцэж байгаа байдал”
2. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал”

<sup>6</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”, Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, УБ, 2016, 306 дахь тал

<sup>7</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”, Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, УБ, 2016, 308 дахь тал

## I. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Практикт нийцэж байгаа байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл байгаа эсэхийг тодорхойлно. Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль амьдрал дээр хэрэгжиж байгаа эсэхийг харуулна. Мөн энэ шалгуур үзүүлэлтээр ихэвчлэн хуулийг хэрэгжүүлэгч этгээдээс болон байгууллагаас уг зохицуулалт практикт хэрэгжиж чадаж байгаа эсэхийг тогтооход түлхүү ашигладаг. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон амьдралд гарч байгаа эерэг болон сөрөг ямар үр дагаврууд байгааг тодорхойлох бөгөөд хуулийн зохицуулалтын ойлгомжтой байдал түүнийг хэрэгжүүлэх боломж бололцоог практикт байгаа эсэхийг тооцох нь чухал юм.<sup>8</sup> Иймд тус шалгуур үзүүлэлтээр ТЕХ-ийн зарим зүйл заалтын практик хэрэгжилт болон гарч буй хүндрэл бэрхшээл тэдгээрийн эерэг сөрөг үр дагаврыг тодорхойлохыг зорилоо.

Хүснэгт 1. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд

Д/Д	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	5 дугаар зүйлийн 5.2	5.2.Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна:
	8 дугаар зүйлийн 8.1.1	8.1.1.бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн борлуулсан бол тухай бүрд;
	10 дугаар зүйлийн 10.2.2	10.2.Бараа, ажил, үйлчилгээ борлуулсан тухай бүрд албан татвар ногдуулах хугацааг доор дурдсан үйлдлийн аль түрүүнд хийгдсэн өдрөөр тогтооно:

<sup>8</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”, Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, УБ, 2016, 314 дэх тал

	<p>13 дугаар зүйлийн 13.1.7, 13.1.15, 13.1.16, 13.1.17, 13.1.18, 13.1.20, 13.1.24, 13.1.28, 13.1.29 13.6</p>	<p>13.1.7.орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байр буюу түүний хэсгийг борлуулсны орлого;</p> <p>13.1.15.газар тариалан эрхлэгчийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, суулгац, жимс жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурил;</p> <p>13.1.16.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрийн аргаар төхөөрч бэлтгэн дотооддоо борлуулсан тураг болон шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн;</p> <p>13.1.17.Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдээр боловсруулан дотооддоо борлуулсан хүнсний сүү, сүүн бүтээгдэхүүн;</p> <p>13.1.18.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, үйлдвэрлэн борлуулсан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл;</p> <p>13.1.20.импортоор оруулж байгаа бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, банз, модон бэлдэц, хагас боловсруулсан модон материал;</p> <p>13.1.24.нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, зөөврийн компьютерийн хувьд 30 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий хувь хүний нэр дээр илгээсэн улс хоорондын шуудангийн илгээмж;</p> <p>13.1.28.сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг.</p> <p>13.1.29.малчдын хоршоо, малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөвөр.</p> <p>13.6.Жилийн 50 саяас доош төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ борлуулсан этгээд /импортоор оруулахаас бусад/-ийг албан татвараас чөлөөлнө.</p>
	<p>14 дүгээр зүйлийн 14.1, 14.1.4, 14.1.5</p>	<p>14.1.5.үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авах, импортлоход төлсөн албан татварыг дараах хугацаагаар хувь тэнцүүлэн хасагдуулна:</p> <p>14.1.5.а.барилга, байгууламж 10 жилээр;</p> <p>14.1.5.б.тоног төхөөрөмж 5 жилээр; /Үүнд хайгуулын үйл ажиллагааны зардал хамаарна./</p> <p>14.1.5.в.энэ хуулийн 14.1.5.а,14.1.5.б-д зааснаас бусад үндсэн хөрөнгийг шууд.</p>

## II. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд иргэд, хуулийн этгээдээс хуулийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл, хуулийг нийгэм хүлээн зөвшөөрч сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр шалгана. Энэ шалгуур үзүүлэлтээр хуулийн зохицуулалтын үр нөлөөг шууд хүртэж байгаа иргэд, хуулийн этгээдийг хамруулж үнэлгээг хийнэ.<sup>9</sup>

Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх заалтыг сонгохдоо дараах асуудлаар бүлэглэж иргэд олон нийтээр хэлэлцүүлж, аж ахуйн нэгж байгууллага, ажлын хэсгээс албан бичгээр санал авсан.

### 1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэрийг сонгох

Үнэлгээ хийхэд тухайн хуулийн үр нөлөө болон үр дүнгийн үнэлгээний үндэс нь тухайн судалж буй зүйлийн ажиглагдаж байгаа болон хэмжихүйц мэдээллийг цуглуулж, түүний зарим үзүүлэлтийн хооронд харьцуулах явдал юм. Эрх зүйн зохицуулалтын үр дүн, үр нөлөөний үнэлгээ нь практик дээр тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлт болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэгдэнэ.<sup>10</sup>

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхдээ асуудал буюу үнэлэх болсон шалтгаан, тогтоосон хүрээ, шалгуур үзүүлэлт зэргээс хамаарч аль болох тохиромжтой харьцуулах хэлбэрийг сонгох нь зүйтэй. Харьцуулах хэлбэрийн хувьд:

- 1/ байх ёстой ба одоо байгаа;
- 2/ хууль батлагдахаас өмнөх ба хууль батлагдсанаас хойш;
- 3/ хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- 4/ тохиолдол судлах; гэж ангилна

#### Хүснэгт 2. “Үнэлгээний харьцуулах хэлбэрийн тайлбар”

д/д	Харьцуулах хэлбэр	Ойлголт, онцлог
1.	Байх ёстой болон одоо байгаа	Хуулиар тогтоосон “байх ёстой” үзүүлэлт практикт хэр байгааг илрүүлэх зорилготой. Үнэлгээ хийх хуульд байвал зохих тодорхой абсолют үзүүлэлтийг зааж өгсөн тохиолдолд одоо бодит байгаа үзүүлэлттэй харьцуулна.
2.	Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах буюу хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй үр дагавартай харьцуулна.
3.	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг он дарааллаар тогтоон харьцуулна.
4.	Тохиолдол судлах	Хууль, эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоогдсон зүйл, заалт өөр орчин нөхцөлд (бусад улсад, өөр орон нутагт гэх зэрэг) хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

НӨАТХ-ийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ “байх ёстой ба одоо байгаа”, “хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш”, “тохиолдол судлах” гэсэн харьцуулах хэлбэрүүдийг судалгаанд ашиглах нь тохиромжтой гэж үзэв.

<sup>9</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”, Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, УБ, 2016, 314 дахь тал

<sup>10</sup> Мөн тэнд 315 дахь тал

1. “Байх ёстой ба одоо байгаа” харьцуулах хэлбэрээр НӨАТХ-ийн практик хэрэгжилт, түүний үр дагаврыг онолын тогтоосон шаардлагатай харьцуулах замаар тус хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтоохыг зорилоо.

2. “Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш” харьцуулах хэлбэрээр НӨАТХ-ийн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг харьцуулна.

3. “Тохиолдол судлах” харьцуулах хэлбэрээр НӨАТХ-ийн зарим зүйл заалтын хүрээгээр тогтоогдсон зүйл заалт, өөр орчин нөхцөлд хэрхэн хэрэгжиж буй байдлыг харьцуулна.

### **1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох**

Үнэлгээний үндсэн хэсэг нь тухайн хуулийн зохицуулалтыг ажиглагдсан буюу практик дээр гарсан үр дагавар, үр нөлөөний явцыг харьцуулах явдал билээ. Энэхүү харьцуулалтыг шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар хэрэгжүүлэх ба тэдгээрийг зөв төсөөлж, томъёолох нь чухал байдаг. Шалгуур үзүүлэлтийг томъёолох гэдэг нь тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамаглалыг дэвшүүлэх, эсхүл асуулт тавихыг хэлнэ.<sup>11</sup>

Судалгааны энэхүү хэсэгт сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлж, “Зорилтод хүрсэн түвшин ямар байна вэ?”, “Практикт хэр нийцэж байна вэ?”, “Хүлээн зөвшөөрөгдөж байна вэ” гэх асуултуудын хүрээнд гарч ирэх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлон томъёолохыг зорилоо.

#### **Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:**

*Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. НӨАТ-ын босго дүн практикт хэрэгжиж байна уу ?*

*Шалгуур үзүүлэлтийн томъёолол 2. НӨАТ-ын борлуулалтын орлогын суурь практикт хэрэгжиж байна уу ?*

*Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. НӨАТ-ын чөлөөлөлт практикт хэрэгжиж байна уу ?*

*Шалгуур үзүүлэлтийн томъёолол 4. НӨАТ-аас хасалт хийх эрх зүйн хэм хэмжээ практикт хэрэгжиж байна уу ?*

#### **Хүлээн зөвшөөрөгдсөн байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд**

*Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.НӨАТХ-ийн нийгэм хүлээн зөвшөөрч сайн дураар сахин биелүүлж байна уу ?*

### **1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох**

---

<sup>11</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”, Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, УБ, 2016, 320 дахь тал

Мэдээлэл цуглуулах буюу судалгаа хийхдээ ямар мэдээлэл, судалгааг хэнээс, хэрхэн, ямар аргаар, хэзээ авахаа оновчтой тодорхойлно. Үүнийг зөв тодорхойлж чадвал санхүү, боловсон хүчин, цаг хугацааг хэмнэх ач холбогдолтой гэдгийг санах хэрэгтэй.<sup>12</sup>

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэр буюу шүүхийн практик, энэхүү сэдвээр бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийг уншиж судлах, түүхчилсэн судалгаа хийх, харьцуулсан судалгаа хийх, судалгааны тайлан унших, харьцуулалт хийх, холбогдох байгууллагаас тоо баримт, судалгаа гаргуулах зэрэг аргыг ашиглана.

Мэдээлэл цуглуулах аргын хувьд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон хэрэгжүүллээ. Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд татварын эрх зүй, тус ажиллагааг хэрэгжүүлэх шүүхийн тухай холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл, гарын авлага, эрдэм шинжилгээний болон бусад хурлын эмхэтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайланг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан болно.

### **ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ**

Хэрэгжүүлэх үе шатны гол зорилго нь хэрэгцээтэй, шаардлагатай байгаа ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах ажиллагааг үнэлгээ хийж буй субъект буюу багийн тусламжтайгаар бодит ажил болгон гардаж хийнэ. Үүнийг хийхдээ судалгааны багийн гишүүд ямар хугацаанд ямар хүрээнд, ямар зохион байгуулалтайгаар хэрхэн, яаж гүйцэтгэхээ өмнөх үе шатанд төлөвлөсний дагуу гүйцэтгэх юм.<sup>13</sup>

НӨАТХ-ийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ ‘баримт бичгийн’ аргыг ашиглав.

*Баримт бичгийн судалгаа:* Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүрээнд холбогдох хууль тогтоомж, сурах бичиг, эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл болон өгүүлэл, судалгааны тайлан, гарын авлага, хурлын эмхэтгэл зэргийг ашигласан. Эдгээр материалын жагсаалтыг судалгааны ашигласан материал хэсгээс дэлгэрэнгүй харна уу.

---

<sup>12</sup> Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”, Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, УБ, 2016, 321 дэх тал

<sup>13</sup> Мөн тэнд 325 дахь тал

## ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

### 3.1. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

#### 3.1.1. НӨАТ-ын босго дүн /НӨАТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2/

Хүснэгт 3. “Практик нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн зүйл, заалт

5 дугаар зүйл. 5 дугаар зүйл. Албан татвар төлөгч, албан татвар суутган төлөгч

5.2. Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төвлөрүүлэх үүрэг бүхий дараах этгээд албан татвар суутган төлөгч байна:

#### Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. НӨАТ-ын босго дүн практикт хэрэгжиж байна уу ?

НӨАТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт нь НӨАТ-ийн босго үнийн дүн хуульчилсан чухал заалт бол мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, 5 дугаар зүйлийн 5.3, 5.5, 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт нь татварын босго дүнтэй хамааралтай заалтууд юм.

Монгол Улсын Их Хурлаас 1998 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Худалдааны татварыг Нэмэгдсэн өртгийн албан татвар болгон өөрчилж, шинэ хууль баталсан. Энэ хуулиар импорт, үйлдвэр, барилга, бөөний болон жижиглэнгийн худалдаа, тээвэр, холбоо, ахуйн үйлчилгээний салбарын хүрээнд үйл ажиллагаа эрхлэгчдийг хамруулан падаан нэхэмжлэхийн аргаар албан татварын суурийг тодорхойлж байсан. Мөн албан татварын хувь хэмжээ 15 хувь, экспортын татвар 0 хувь, нэлээд олон төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлт байсан. Албан татварын хувь хэмжээг 15 байсныг хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2 сарын дараа 13 хувь болгон бууруулсан нэмэлт өөрчлөлт оржээ. Энэ хувь хэмжээг 2001 оныг хүртэл мөрдөж, 2001 оны 01 сарын 01-нээс 15 хувь болгон нэмэгдүүлжээ.

Татварын багц хуулийн эхний шинэчлэлийн хүрээнд 2006 оны 06 дугаар сард Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг дахин шинэчлэн найруулсан. Энэ өөрчлөлтөөр өмнөх хуулиас агуулга, зарчмын өөрчлөлт байхгүй хэдий ч цар хүрээ, бааз суурийг өргөжүүлснээрээ давуу талтай. Энэхүү 2006 оны хууль 10 бүлэг 18 зүйлтэйгээр батлагдсан. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хувь хэмжээ нь 10 хувь, албан татвар төлөгчөөр бүртгүүлэх босго нь 10 сая төгрөг, экспортын 6 төрлийн бараа, ажил, үйлчилгээнд 0 хувиар албан татвар ногдуулж, 14 төрлийн бараа, 15 төрлийн үйлчилгээг Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зохицуулалттай байсан.

НӨАТХ-ийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 07 сарын 09-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас 9 бүлэг 18 зүйлтэйгээр батлагдаж, 2016 оны 01 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж байна. Энэ хуулийн үйлчлэх хүрээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараа, ажил, үйлчилгээ болон Монгол Улсаас экспортод гаргасан, Монгол Улсад импортоор оруулсан бараа, ажил, үйлчилгээнд албан татвар ногдуулах харилцааг зохицуулж байна. Өөрөөр хэлбэл нутаг дэвсгэрийн зарчмаар албан татварыг ногдуулдаг. Мөн өмнөх хуулиудаас ялгаатай, онцлог нь Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч нь суутган татвар төлөгчөөр бүртгүүлэх босгын хэмжээг 10 сая төгрөг байсныг 50 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн.<sup>14</sup>

<sup>14</sup> НӨАТ-ын тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга, үзэл баримтлал

НӨАТХ-ийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д Албан татвар төлөгчийн үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган төлөгч байна гэж заасан. Энэхүү босгыг тооцохдоо олон улсын жишиг аргачлалын баримталсан бөгөөд тухайн үеийн /2015 оны/ 50 сая төгрөг өнөөдрийн 400 сая төгрөгтэй тэнцэж байгаа тооцоолол гарсан.<sup>15</sup>

Түүнчлэн Улсын Их Хурлын Даргын 2024 оны 292 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг, Төсвийн байнгын хороо хамтран “Татварын хуулийн шинэчлэл” сэдвээр цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулж эхэлсэн. Энэ хүрээнд 2025 оны 1 дүгээр сарын 30-ны өдөр “Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”-ын танхим зохион байгуулсан.<sup>16</sup> Тус хэлэлцүүлэгт татварын багц хуулийн хэрэгжилттэй танилцаж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол холбогдох хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг хэлэлцүүлгийг нээж хэлсэн үгэндээ татварын хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор татвар тус бүрээр нь хэлэлцүүлэг зохион байгуулж буйг тодотгоод өнөөдрийн байдлаар нийтдээ 110 мянга гаруй иргэн, аж ахуйн нэгжээс, санал авсныг дурдсан. Тодруулбал, НӨАТ-ын хүрээнд Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорнод, Хөвсгөл, Сүхбаатар аймаг, МҮХАҮТ, ТЕГ-т зохион байгуулсан татварын шинэчлэлтэй холбоотой хэлэлцүүлгээр НӨАТ-ын босго үнэтэй холбоотой дараах саналыг ирүүлжээ.

*Хүснэгт 4.. “НӨАТ-ын босго дүнтэй холбоотой олон нийт, ААН-ээс ирүүлсэн саналын нэгтгэл*

НӨАТ-ын суутган төлөгчөөр бүртгүүлэх дүнтэй холбоотой саналын нэгтгэл			
№	Өөрчлөх санал	Шалтгаан	Давтамж
1.	НӨАТ-ын босго 50 сая төгрөгийг нэмэгдүүлэх. 100-200-300-500 сая болгож өөрчлөх	<ul style="list-style-type: none"> <li>НӨАТ төлөгч болохгүй тулд энэ үнийн дүнд хүрэхгүй байх арга замыг ашигладаг.</li> <li>ААН, байгууллага неат баримт өгөх сонирхолгүй.</li> <li>ААН, байгууллага томрох сонирхолгүй байна.</li> </ul>	"УБ танхим 1.20 1.23 1.27 1.30 УИХ 1.20 өдрийн хэлэлцүүлэг "Говь-Алтай Говьсүмбэр Дархан-Уул Дорнод Хөвсгөл Сүхбаатар Чингэлтэй дүүрэг болсон хэлэлцүүлэг.
2.	НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэх борлуулалтын орлогын босго дүн байх	<ul style="list-style-type: none"> <li>Зарим нь ААН, байгууллага НӨАТ төлөгч бус үед НӨАТ төлөгч бус</li> </ul>	"УБ танхим 1.20 1.23

<sup>15</sup> ОУВС, Торонтогийн Их сургуулийн хамтарсан судлаачид 2004 онд Майкл Кийн, Жак Минзийн “НӨАТ-ын босгын хэмжээг оновчтой тогтоох загвар”


<sup>16</sup> “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж байна, <https://www.parliament.mn/nn/74036>

	шаардлагагүй.	<p>ААН-ээс бараа авахаар Худалдан авагч ААН-д дарамт болдог.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Барс зах, Нарантуул зах, 100 айл, Өгөөмөр зах - баримт өгдөггүй.</li> <li>• Жижиг бизнес эрхлэгч баримт өгөхгүй болохоор тэр баримтыг компаниуд тайлан дээрээ тусгахын тулд нэмэлт зардал гаргадаг.</li> </ul>	<p>1.27 1.30 УИХ 1.30-2" "Говь-Алтай Говьсүмбэр Дорнод"</p>
--	---------------	--	---

Мөн албан бичгээр НӨАТ-ын босго үнийн дүнтэй холбоотой дараах саналыг ирүүлжээ. Тодруулбал, НӨАТ-ын босгыг өндөр болгох хэрэгтэй, ядаж 300,0 сая болгох хэрэгтэй, Өнөөдрийн 50,0 сая төгрөг гэдэг чинь одоо жилээр нь тооцвол өдрийн 137 мянган төгрөг байгаа, өнөөдөр жижиг ТҮЦ-ч ийм орлого олохгүй, тэгэхээр босгыг нэмэх нь зүйтэй байна. НӨАТ суутган төлөгчийн босгогүй болгож, татварын хувь хэмжээг 5% болгон бууруулах нь бодит байдалтай уялдсан, далд эдийн засгийг ил болгох, татварын суурийг нэмэгдүүлэх, зэрэг чухал ач холбогдолтой оновчтой зохицуулалт болохоор байна.

ТЕГ-аас цахим хэлбэрээр “Татварын хуулийн шинэчлэл” нэртэй судалгааг авсан. 2025 оны 01 сарын 20 -нд эхэлсэн бөгөөд мөн оны 2 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 12813 татвар төлөгч оролцсон.

График 1. “Татварын хуулийн шинэчлэл” судалгаанд оролцсон татвар төлөгчийн мэдээлэл



Графикаас үзвэл тус судалгаанд хамрагдсан 12813 этгээд хамрагдсаны 73.9% иргэн, үлдсэн 26.1% хувь хуулийн этгээд байна.

График 2. “Татварын хуулийн шинэчлэл” судалгаагаар НӨАТ-ын босго

хэмжээнд ирүүлсэн санал

## 2.НӨАТ-ын босгын хэмжээ

Хуулах

3,556 хариулт




График 2-оос үзвэл НӨАТ-ын босго хэмжээний хүрээнд 3556 санал ирсэн бөгөөд үүний 24.3% нь НӨАТ-ыг босгогүй болгох, 22.8% нь НӨАТ-ын босгыг 300 сая болгох, 21.4% нь НӨАТ-ын босгыг 400 сая болгох саналыг илгээжээ.

Иймд, НӨАТтХ-иар тодорхойлсон босго дүн болох 50 сая төгрөгийг нэмэгдүүлэх, өнөөгийн үнэ цэнэ, татварын үр ашигт байдлыг харгалзан үзэх шаардлага үүсч байна.

### 3.1.2. НӨАТ-ийн борлуулалтын орлогын суурь /НӨАТтХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1,10.2.2/

Хүснэгт 5. “Практик нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн зүйл, заалт

8 дугаар зүйлийн 8.1.1

8.1.1.бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн борлуулсан бол тухай бүрд;

10 дугаар зүйлийн 10.2.2

10.2.Бараа, ажил, үйлчилгээ борлуулсан тухай бүрд албан татвар ногдуулах хугацааг доор дурдсан үйлдлийн аль түрүүнд хийгдсэн өдрөөр тогтооно:

### Шалгуур үзүүлэлтийн томьёолол 2. НӨАТ-ын борлуулалтын орлогын суурь практикт хэрэгжиж байна уу ?

ТЕХ-ийн 28 дугаар зүйлд татвар ногдуулалт төлөлттэй холбоотой эрх зүйн хэм хэмжээг хуульчилсан. Тодруулбал, тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д “Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ”

гэж хуульчилсан. Уг заалтаас татвар төлөгч ногдуулалтыг орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдсэний хийхээр хуульчилсан.<sup>17</sup>

Энэ ч утгаараа НӨАТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.14-д “төлбөрийн баримт” гэж “ тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг” ойлгохоор хуульчилсан.<sup>18</sup>

Мөн Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.26-д “төлбөр тооцоо” гэж хоёр ба түүнээс дээш талын хооронд хийгдсэн мөнгөн хөрөнгө, үнэт цаасны төлбөрийг дансанд тусгах ажиллагааг гэж ойлгохоор тус тус хуульчилсан.

Дээрхээс Татвар төлөгчид НӨАТ-ын ногдуулахдаа орлого болон зардлын гүйлгээг бүртгэж, баримтжуулахдаа төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох мэдээлэл агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг үндэслэхээр байна.

Гэвч НӨАТХ-ийн 8 дугаар зүйл “Албан татвар ногдуулах” – ийн 8.1.1-д “бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн **борлуулсан бол** тухай бүрд”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-д “10.2.2.бараа, ажил, үйлчилгээг борлуулсан” өдрөөс НӨАТ ногдуулахаар хуульчилсан. Энэ нь ТӨХ болон НӨАТХ-ийн ерөнхий заалттай зөрчилдөж байна.

Өөрөөр хэлбэл борлуулалт гэж барааг бусдын өмчлөлд шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхийг хэлдэг бөгөөд үүнтэй холбоотойгоор бараа, ажил, үйлчилгээг борлуулсан бол тухай бүрд нь буюу барааг бусдын өмчлөлд шилжүүлсэн, ажил үйлчилгээг үзүүлснээр НӨАТ-ыг ногдуулж байна.

Энэ нь бараагаа шууд мөнгөөр борлуулсан буюу борлуулсан даруйд төлбөр тооцоо хийгдсэн тохиолдолд ямар нэгэн хүндрэл байхгүй. Харин борлуулсан барааны төлбөрийг тодорхой хугацааны дараа авах нөхцөл (энэ нь бизнесийн хэвийн нөхцөлд маш түгээмэл байдаг нөхцөл) - өөр борлуулалт хийгдсэн тохиолдолд гажуудал үүсгэж байна.

Учир нь төлбөр тооцоо хийгдээгүй, орлого нь мөнгөөр орж ирээгүй байхад, борлуулалт хийгдсэн гэдгээр татвар ногдуулаад татварын өртэй болдог, татварт төлөх мөнгө нь бэлэн байхгүй, өрөө төлж чадахгүй байснаас болж дансаа хаалгадаг, тендерийн гэх мэт шаардлагаар тодорхойлолт авахад татварын өртэй гэж гардаг зэрэг олон хүндрэл үүсдэг байна.

Энэ санал иргэд, олон нийтийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, албан бичиг, судалгаанд дурдагдаж байна. Тодруулбал, НӨАТ ногдуулахдаа НӨАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “борлуулсан тухай бүрд”, 10 дугаар зүйлийн 10.2.2-д “борлуулж”, 14 дүгээр зүйлийн 14.3-д “бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилсэн үзүүлсэн тухай бүрд” гэж заасныг баримталдаг. Гэвч эдгээр утга нь цаг хугацааны хувьд ялгаатай ойлголт гэдгийг харгалзах өөрчлөх шаардлагатай талаарх санал ТӨГ газарт ирүүлсэн.

<sup>17</sup> Татварын Ерөнхий хууль, УБ, 2019, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14403>

<sup>18</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, УБ, 2015, <https://legalinfo.mn/mn/detail/11227>

График 3. Татварын хуулийн шинэчлэл” судалгаагаар НӨАТ-ын борлуулалтын орлогын мөнгөн суурийн хүрээнд ирүүлсэн санал



График 3-аас үзвэл,НӨАТ-ын борлуулалтын орлогыг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрөх судалгаанд 3556 иргэн, хуулийн этгээд хамрагдсан бөгөөд үүний 64.5% хувьд НӨАТ-ын борлуулалтын орлогыг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрөхийг дэмжсэн бол, 32.8% нь НӨАТ-ын борлуулалтын орлогыг мөнгөн сууриар хүлээн зөвшөөрөхийг дэмжээгүй байна.

Түүнчлэн, НӨАТХ-ийн 8 дугаар зүйлийн агуулга нь тус татварыг ногдуулах цаг хугацааны дарааллыг тогтоосон. Гэвч мөн хуулийн 10 дугаар зүйлд “Албан татвар ногдуулах хугацаа” гэсэн давхардсан заалт оруулсан. Өөрөөр хэлбэл, НӨАТ төлөгч НӨАТХ-ийн 8.1.1.бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн борлуулсан бол тухай бүрд; 8.1.2.санхүүгийн түрээсийн зүйлийг худалдан авсан бол түрээсийн төлбөр хийхээр тохирсон хуваарийг баримтлан тухай бүрд; 8.1.3.энэ хуулийн 7.2.16-д заасан шаардах эрхийг худалдан авах санхүүжилтийн хэлэлцээрийн зүйлийг худалдан авсан бол төлбөр хийхээр тохирсон хуваарийг баримтлан тухай бүрд НӨАТ төлөгч болохоор байна. Энэ агуулгыг давхардсан байдлаар НӨАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2-д “Бараа, ажил, үйлчилгээ борлуулсан тухай бүрд албан татвар ногдуулах хугацааг доор дурдсан үйлдлийн аль түрүүнд хийгдсэн өдрөөр тогтооно” гэж хуульчилсан байгааг анхаарах нь зүйтэй.

### 3.1.3. НӨАТ-ийн чөлөөлөлт /13 дугаар зүйлийн 13.1.7, 13.1.15, 13.1.16, 13.1.17, 13.1.18, 13.1.20, 13.1.24, 13.1.28, 13.1.29 13.6/

Хүснэгт 6. “Практик нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн зүйл, заалт

13 дугаар зүйл.Албан татвараас чөлөөлөх

13.1.7.орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа байр буюу түүний хэсгийг борлуулсны орлого;

13.1.15.газар тариалан эрхлэгчийн дотооддоо тарьж борлуулсан үр тариа, төмс, хүнсний ногоо, суулгац, жимс жимсгэнэ, үйлдвэрлэсэн гурил;

13.1.16.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрийн аргаар төхөөрч бэлтгэн дотооддоо борлуулсан тураг болон шулж ангилсан мах, боловсруулаагүй дотор эрхтэн, дайвар бүтээгдэхүүн;

13.1.17.Монгол Улсын нутаг дэвсгэрт дотоодын түүхий эдээр боловсруулан дотооддоо борлуулсан хүнсний сүү, сүүн бүтээгдэхүүн;

13.1.18.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн, үйлдвэрлэн борлуулсан жижиг, дунд үйлдвэрийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл;

13.1.20.импортоор оруулж байгаа бөөрөнхий мод, гуалин, зүсмэл материал, банз, модон бэлдэц, хагас боловсруулсан модон материал;

13.1.24.нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин, зөөврийн компьютерийн хувьд 30 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй, ижил төрлийн хоёроос илүүгүй бараа бүхий хувь хүний нэр дээр илгээсэн улс хоорондын шуудангийн илгээмж;

13.1.28.сэргээгдэх эрчим хүчний судалгаа шинжилгээний болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, түүний дагалдах хэрэгсэл, сэлбэг.

13.1.29.малчдын хоршоо, малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөөвөр.

13.6.Жилийн 50 саяас доош төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ борлуулсан этгээд /импортоор оруулахаас бусад/-ийг албан татвараас чөлөөлнө.

### Шалгуур үзүүлэлтийн томъёолол 3. НӨАТ-ын чөлөөлөлт практикт хэрэгжиж байна уу ?

Манай Улсад татварын хуультай холбоотой санал, асуулга явуулахаар НӨАТ-ын талаар санал ирдэг. Уг татвар бизнест дарамт учруулдаг үндсэн асуудал нь чөлөөлөлт байдаг. НӨАТ-ын чөлөөлөлт нь борлуулалт, худалдан авалтын хасалт гэдэг гинжин хэлхээг эвддэг тул хамгийн их сөрөг нөлөөг үзүүлдэг. Иймд НӨАТ-ын шинэчлэлийн хүрээнд чөлөөлөлт, хөнгөлөлтийн асуудлыг оновчтой болгох шаардлагатай. Одоогоор Монгол Улсад нийт 28 төрлийн бараа, 19 төрлийн үйлчилгээ уг татвараас чөлөөлөгдөх зохицуулалттай байна.<sup>19</sup> Мөн тодорхой салбарт, тодорхой хугацаатайгаар Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн 40 гаруй хууль үйлчилж байна.

Хүснэгт 7. НӨАТ-ийн чөлөөлт эдэлсэн байдал 13 дугаар зүйлийн 13.1.13-13.5.3

<sup>19</sup> “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж байна, <https://www.parliament.mn/nn/74036/>

Дд	хуулийн заалт	Чөлөөлт эдэлж буй заалт	2020 он		2021 он		2022 он		2023 он		2024 он		график
			ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	
нийт дүн (давхардсан)			1,477	967.74	9,041	20,622.43	9,638	26,474.32	11,384	41,061.86	10,365	48,122.10	
1	13-р зүйл 1.13	12.1.7-с бусад экспортод гаргасан аш ишт малмал	39	556.62	104	12,851.23	113	15,488.81	151	28,034.62	114	32,275.08	
2	13-р зүйл 5.7	зээлийн хүү	62	146.95	182	2,691.29	267	4,519.85	1,929	5,672.09	1,570	7,097.87	
3	13-р зүйл 1.11	борлуулсан алт	5	35.95	58	1,087.19	69	1,408.59	59	1,604.03	45	1,846.72	
4	13-р зүйл 5.5	зээл олгох үйлчилгээ	12	86.31	50	907.36	74	958.64	102	1,400.11	89	1,557.30	
5	13-р зүйл 1.3	гадаад улсын эг-н санхүүжилтээр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ /сс-ын журам/	464	14.23	2,389	508.78	2,488	799.95	2,326	636.24	2,001	812.91	
6	13-р зүйл 1.21	угаасан самнасан ноосуур, арьс шир	7	4.70	23	517.66	45	799.64	48	711.72	52	765.95	
7	13-р зүйл 1.15	дотоодод тарьж борлуулсан үр тариа, төмс ногоо, үйлдвэрлэсэн гурил	110	26.61	1,144	403.44	1,322	429.17	1,181	541.92	1,080	580.10	
8	13-р зүйл 5.2	банкны үйлчилгээ	45	10.78	45	134.46	47	206.64	106	154.58	133	455.66	
9	13-р зүйл 5.10	эрүүл мэндийн үйлчилгээ	110	12.69	311	282.38	327	311.33	360	365.68	360	416.32	
10	13-р зүйл 1.16	дотоодод бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүн	56	8.93	686	270.03	792	239.99	700	383.84	627	404.17	
11	13-р зүйл 1.17	сүү, сүүн бүтээгдэхүүн	98	4.80	785	73.57	894	98.82	732	116.44	665	271.01	
12	13-р зүйл 5.9	боловсрол олгох үйлчилгээ	55	5.74	233	114.86	305	163.40	336	233.98	303	260.77	
13	13-р зүйл 5.12	төрийн байгууллагын үйлчилгээ	31	0.50	565	70.71	837	136.59	1,060	208.87	1,130	254.21	
14	13-р зүйл 5.1	валют солих үйлчилгээ	9	1.19	20	7.89	51	248.31	57	76.53	30	213.72	
15	13-р зүйл 1.9	хийн түлш, сав, техник хэрэгсэл	28	4.46	148	119.84	186	175.63	186	166.62	158	177.37	
16	13-р зүйл 5.14	аялал жуулчлалын үйлчилгээ	8	1.11	33	10.79	94	54.05	103	85.85	126	121.18	
17	13-р зүйл 5.3	даатгалын үйлчилгээ	31	2.06	85	64.18	100	87.97	138	118.68	136	99.06	

Хүснэгт 8. НӨАТ-ийн чөлөөлт эдэлсэн байдал 13 дугаар зүйлийн 13.5.13-13.5.4.

Дд	хуулийн заалт	Чөлөөлт эдэлж буй заалт	2020 он		2021 он		2022 он		2023 он		2024 он		график
			ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	
18	13-р зүйл 5.13	нийтийн тээврийн үйлчилгээ	24	1.92	73	49.47	101	64.58	104	83.52	98	93.20	
19	13-р зүйл 5.4	үнэт цаас, хувьцаа борлуулах, хүлээн авах	8	25.06	19	212.31	25	49.88	31	180.25	31	69.52	
20	13-р зүйл 5.8	орон сууц хөвлүүлэх үйлчилгээ	36	2.11	108	43.84	118	43.04	125	50.72	141	53.75	
21	13-р зүйл 1.6	иргэний агаарын хөлөг, эд анги, сэлбэг	3	0.06	31	27.08	49	4.44	52	19.27	33	45.16	
22	13-р зүйл 1.19	инновац шинэ бүт үйлдвэрлэхэд шаардлагатай дотоодод үйлдвэрлэдэггүй түүхий эд, материал, урвалж бодис	3	0.00	39	13.79	68	3.61	67	33.26	86	38.24	
23	13-р зүйл 1.28	сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж, сэлбэг	5	0.02	99	11.08	143	36.90	156	38.23	148	37.43	
24	13-р зүйл 1.27	чөлөөт бус дэх зорчигчийн бараа	-	-	13	2.22	33	7.27	39	24.20	33	29.76	
25	13-р зүйл 1.7	орон сууц, түүнийг борлуулсны орлого	14	0.56	98	24.63	103	17.47	107	18.58	154	29.63	
26	13-р зүйл 5.16	оршуулгын үйлчилгээ	5	1.05	13	27.13	10	25.33	12	23.73	9	27.69	
27	13-р зүйл 1.4	хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусгай зориулалтын хэрэгсэл, тоног төхөөрөмж	14	0.85	190	10.99	255	12.63	257	19.81	223	22.17	
28	13-р зүйл 5.11	шашны байгууллагын үйлчилгээ	5	0.00	22	7.87	37	13.05	26	13.32	27	17.16	
29	13-р зүйл 1.18	дотоодод үйлдвэрлэсэн ждү тоног төхөөрөмж	12	0.36	170	3.90	186	10.26	204	15.38	230	13.97	
30	13-р зүйл 1.26	газрын тос, дээж	1	0.00	41	5.57	52	14.55	54	7.51	75	7.22	
31	13-р зүйл 1.14	үнэт цаас гаргах зориулалтаар шилжүүлсэн зээл	-	-	37	3.52	74	21.65	131	6.92	125	5.77	
32	13-р зүйл 5.18	мал эмнэлгийн үйлчилгээ	3	0.01	56	1.16	71	1.35	92	4.75	67	5.06	
33	13-р зүйл 1.12	эрдэм шинжилгээ, судалгааны бүтээгдэхүүн	6	0.06	86	2.51	129	4.84	183	8.36	121	4.70	
34	13-р зүйл 5.4	үнэт цаасны үйлчилгээ	-	-	3	0.02	4	2.21	8	3.86	5	4.70	

Хүснэгт 9. НӨАТ-ийн чөлөөлт эдэлсэн байдал 13 дугаар зүйлийн 13.1.8- 13.1.25.

Дд	хуулийн заалт	Чөлөөлт эдэлж буй заалт	2020 он		2021 он		2022 он		2023 он		2024 он		график
			ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	ТТгоо	Дүн	
35	13-р зүйл 1.8	эмчилгээний зориулалтаар хэрэглэх цус, эд эрхтэн	8	0.05	45	5.59	40	3.82	39	4.26	38	4.25	
36	13-р зүйл 1.22	соёлын өвийг судалж шинжлэх багаж, техник, бодис	5	0.02	14	1.55	21	0.99	30	1.98	28	1.26	
37	13-р зүйл 5.20	виртуал хөрөнгийн үйлчилгээ	-	-	-	-	16	2.06	14	0.63	9	0.89	
38	13-р зүйл 5.14	соёлын өвийг сэргээн засах үйлчилгээ	7	0.08	14	0.24	20	1.46	16	1.28	24	0.68	
39	13-р зүйл 5.6	нд, эмд сангийн хүү	-	-	17	0.07	27	3.27	21	0.09	14	0.34	
40	13-р зүйл 5.17	ирээдүйн өв сангийн орлого	-	-	16	1.47	21	1.94	13	0.10	12	0.14	
41	13-р зүйл 5.19	нотариатын үйлчилгээ	-	-	15	0.05	24	0.31	29	0.05	15	0.03	
42	13-р зүйл 14	гадаад улсын эг, оу-ын байгууллагын санхүүжилт	55	7.35	460	37.24	-	-	-	-	-	-	
43	13-р зүйл 1.1	зорчигчийн ачаа	32	3.70	173	2.46	-	-	-	-	-	-	
44	13-р зүйл 1.2	дипломат албаны хэрэгцээнд оруулж ирсэн бараа	54	0.75	269	9.16	-	-	-	-	-	-	
45	13-р зүйл 1.5	хууль хүчний байгууллагын хэрэгцээнд оруулж ирсэн зэвсэг, тусгай хэрэгсэл	2	0.10	16	0.45	-	-	-	-	-	-	
46	13-р зүйл 1.24	хувь хүний нэр дээл илгээсэн шуудангийн илгээмж	2	0.01	6	0.05	-	-	-	-	-	-	
47	13-р зүйл 1.20	мод гуалин, модон эдлэл	3	0.00	8	0.09	-	-	-	-	-	-	
48	13-р зүйл 1.10	гадаадад хийлгэсэн мөнгөн тэмдэгт	-	-	2	0.01	-	-	-	-	-	-	
49	13-р зүйл 1.25	газрын тосны салбарт зориулсан техник, материал, түүхий эд, түлш	-	-	27	1.27	-	-	-	-	-	-	

Дээрх 3 хүснэгтэд хөнгөлөлт чөлөөлөлт эдэлж буй татвар төлөгчийн тоог 2020-2024 оны хооронд харуулсан. Тодруулбал, НӨАТ-ын чөлөөлөлтийг салбараар нь судлахад: Уул уурхай олборлолт 66.6%, Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 18.3%, Боловсруулах үйлдвэрлэл 5.1%, Бөөний болон жижиглэн худалдаа 3.72%, Барилга 2.3%, Эрүүл 0.9% тус тус байна.

НӨАТ нь эцсийн хэрэглэгч төлдөг үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний шат дамжлага бүрд хасаж, үйлдвэрлэлийн шат дамжлагт нэмж үүссэн өртөг, ашигт ногдуулдаг. Үйлдвэрлэл худалдаа, үйлчилгээний шат дамжлага буюу нийлүүлэлтийн гинжин хэлхээний аль нэг үе шатыг НӨАТ-аас чөлөөлж буй нь тус хуулийн хэрэгжилт болон дараагийн шатны дамжлагад хүндрэл үүсгэж байна.

Тухайлбал: Одоогийн мөрдөж буй НӨАТ-ийн 13 дугаар зүйлийн 13.1.16, 13.1.17 анхан шатны боловсруулалтад ороогүй малын гаралтай түүхий эдийг худалдан авч, сүү, сүүн бүтээгдэхүүн, шулж ангилсан махны борлуулалт буюу зөвхөн үйлдвэрлэгчийг НӨАТ-аас чөлөөлсөн. Харин мөн хуулийн 13.10-д энэ дээрх бүтээгдэхүүний дамжуулан борлуулагч нарт хамаарахгүй гэж заасан. Энэ нь тухайн бүтээгдэхүүнийг худалдан борлуулагч этгээдийн хувьд хасалт хийх боломжгүй тул хүндрэл үүсгэж, улмаар эцсийн хэрэглэгчид очих бүтээгдэхүүний үнийг өсгөхөд нөлөөлж байна.

Энэ ч утгаараа хэлэлцүүлэг болон албан бичгээр НӨАТ-аас чөлөөлөхтэй холбоотой асуудлын хүрээнд цөөнгүй санал ирсэн.

*Хүснэгт 10.НӨАТ-аас чөлөөлөх, бараа, ажил үйлчилгээтэй холбоотой албан бичгээр ирсэн саналын нэгтгэл*

НӨАТ-аас чөлөөлөх бараа, ажил үйлчилгээтэй холбоотой саналын нэгтгэл			
№	Өөрчлөх санал	Шалтгаан	Давтамж
1.	НӨАТ-с чөлөөлөгдөх заалтуудыг байхгүй болгох, бүгд ижил тэгш байх	<ul style="list-style-type: none"> <li>• Бие даасан хуулиар чөлөөлдөгийг бүр болих</li> <li>• Алтны борлуулалтыг НӨАТ-тай болгох</li> <li>• Алт чөлөөлөгддөг. Дагалдаж мөнгө гардаг. Дагалдах элементийн НӨАТ-тай холбоотой асуудлыг анхаарах</li> </ul>	"УБ танхим 1.20 1.23 1.27 1.30  УИХ 1.28-2"
2.	НӨАТ-аас чөлөөлдөг болох	<ul style="list-style-type: none"> <li>• "Нийтэд зориулсан төрийн үйлчилгээг чөлөөлөх,</li> <li>• ОУ гэрээгээр зохицуулсан бол - чөлөөлнө. УБТЗ гэх мэт</li> <li>• НӨАТ-ыг ногдуулахад төвөгтэй ажил, үйлчилгээг чөлөөлөх,</li> <li>• Хуулийн хүрээнд гарсан Байгал орчинд ээлтэй, дэд бүтцийн томоохон төслүүдэд оролцогчдод хөнгөлөлт, чөлөөлт олгох</li> <li>• Манайх эко ариун цэврийн цаас үйлдвэрлэдэг бөгөөд энэ нь НӨАТ-с чөлөөлөгдөхгүй байна. Дахин боловсруулах үйлдвэрийг НӨАТ-с чөлөөлдөг болгох</li> </ul>	"УБ танхим 1.20 1.23 1.27 1.30  УИХ 1.28-2"

		<ul style="list-style-type: none"> <li>• Аудитын үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлдөг болох</li> <li>• Уул уурхайн бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлдөг болох - буцаан олголт үүсэхгүй - Алттай адил болгох"</li> </ul>	
3.	Гинжин хэлхээг бүхэлд нь чөлөөлөх	<ul style="list-style-type: none"> <li>• "Мах - ХАА үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэр 2-ын хооронд НӨАТ-ын асуудал үүсэж байна. Чөлөөлбөл сүлжээгээр нь чөлөөлөөд, үгүй бол хувийг нь багасгаад бүгд ижил НӨАТ төлдөг болмоор байна</li> <li>• НӨАТ 13 дугаар зүйл боловсруулах үйлдвэрүүддээ маш их ачаалал өгдөг. Бид тэдний өмнөөс нэмж төлж байна. Эсвэл 14 заалт дээр хасагдвал тооцож болно.</li> <li>• Импортын НӨАТ - бэлэн бүтээгдэхүүнийг чөлөөлсөн хирнээ яг тэр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ордог ТЭМ-ийг чөлөөлөхгүй. Үйлдвэрээ дэмжсэн бодлого алга - 1.28 ААНОАТ</li> <li>• НӨАТ-ын тухай хуулийн 13-р зүйл буюу чөлөөлөлтийг хүчингүй болгох эсвэл 14.1.4-т хамруулан НӨАТ шингэсэн гэж үзээд хасалт хийдэг болгох"</li> </ul>	"УБ танхим 1.20 1.23 1.27 1.30  УИХ 1.28-2"

Дээрхээс үзвэл, НӨАТХ-ийн 13 дугаар зүйл буюу албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг сайжруулах, одоогийн зохицуулалтыг өөрчлөх хэрэгцээ, шаардлага бий болсон.

### 3.1.4. НӨАТ-аас хасалт хийх /НӨАТХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1.5/

*Хүснэгт 11. "Практик нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн зүйл, заалт*

<p><b>14 дүгээр зүйл. Албан татварт хасалт хийх</b></p> <p>14.1. Хувь хүн, хуулийн этгээдийн албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлснээс хойшх хугацаанд энэ хуулийн 7, 8, 11 дүгээр зүйлд заасны дагуу төлсөн доор дурдсан албан татварыг түүний төсөвт төлөх албан татвараас хасч тооцно:</p> <p>14.1.5. үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авах, импортлоход төлсөн албан татварыг дараах хугацаагаар хувь тэнцүүлэн хасагдуулна:</p> <p>14.1.5.а. барилга, байгууламж 10 жилээр;</p> <p>14.1.5.б. тоног төхөөрөмж 5 жилээр; /Үүнд хайгуулын үйл ажиллагааны зардал хамаарна./</p> <p>14.1.5.в. энэ хуулийн 14.1.5.а, 14.1.5.б-д зааснаас бусад үндсэн хөрөнгийг шууд</p>
--

#### Шалгуур үзүүлэлтийн томьёолол 4. НӨАТ-аас хасалт хийх эрх зүйн хэм хэмжээ практикт хэрэгжиж байна уу ?

НӨАТХ-ийн 14 дүгээр зүйлд албан татварт хасалт хийх эрх зүйн орчныг хуульчилсан. Хасалт гэдэг нь албан татвар суутган төлөгчийн төлсөн албан татварыг хасалт хийх, буцаан олгох ойлголтыг илэрхийлдэг.<sup>20</sup>

Гэвч тус хуулийн 2019 оны 3 дугаар сарын 22-ны өдөр өөрчлөн найруулсан 14 дүгээр зүйлийн 14.1.5-д дахь заалтыг хэрэгжүүлэхэд практикт хүндрэл тулгарч байна. Хуульд өөрчлөлт, орохоос өмнө үндсэн хөрөнгөд төлсөн НӨАТ-ыг хувь тэнцүүлэн хасч тооцдоггүй, өөрөөр хэлбэл үндсэн хөрөнгөд төлсөн НӨАТ-ын хөрөнгө худалдан авахад төлсөн НӨАТ-ыг үндсэн хөрөнгийн өртөгт шингээн бүртгэж, капиталжуулдаг байсан.

Одоогийн хуулиар барилга, байгууламж хувьд 10 жил, тоног төхөөрөмжийн хувьд 5 жилээр хувь тэнцүүлсэн хасалтыг хийхээр хуульчилсан. Энэ нь барилга байгууламжид төлсөн НӨАТ-ын 120 сар, тоног төхөөрөмжид төлсөн НӨАТ-ыг 60 сар хувааж хасалт хийх нөхцөлийг бүрдүүлжээ.

Жишээгээр тайлбарлавал та 1,000,000,000 /тэрбум төгрөгөөр/ барилга худалдаж авах үед 10 хувийн НӨАТ–болох 100,000,000 төгрөг нийт 1,100,000,000 саяаар барилгыг худалдаж авах юм. Хэрвээ НӨАТХ-ийн 14.1.5а дахь заалт байгаагүй бол нөат төлсөн 100,000,000 зуун саяыг худалдан авалт хийсэн сардаа НӨАТ хасалт хийж бүртгэх боломжтой. Харин НӨАТХ-ийн 14.1.5а дахь заалт үйлчилж байгаа учраас худалдаж авснаас хойш 10 буюу нийт 120 сарын хугацаанд сард бүр 833,333 /найман зуун гучин гурван мянган төгрөгөөр/ хасалт хийгдэнэ. Тоног төхөөрөмжийн хувьд мөн дээрх зарчим үйлчлэх юм. Энэ татвар төлөгчид санхүүгийн хүндрэлийг бий болгож байна гэж татвар төлөгчид үздэг.

*Хүснэгт 12. Барилга байгууламж, тоног төхөөрөмжөөс хувь тэнцүүлэн*

*хасалт хийсэн дүн мэдээ 2020-2024*

Он	барилга байгууламж		машин,тоног төхөөрөмж		бусад үндсэн хөрөнгө		Хайгуулын үнэлгээний хөрөнгө	
	Тоо	Татварын дүн	Тоо	Татварын дүн	Тоо	Татварын дүн	Тоо	Татварын дүн
2021	27	100	345	446	1,210	272		
2022	79	197	534	709	1,610	243		-
2023	51	226	710	1,121	2,040	365		-
2024	81	319	197	1,634	2,531	264.04		
	<b>238</b>	<b>841</b>	<b>1,786</b>	<b>3,911</b>	<b>7,391</b>	<b>1,144</b>		-


<sup>20</sup> Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам, <https://legalinfo.mn/mn/detail?lawid=206987>

График 4. "Татварын хуулийн шинэчлэл" судалгаагаар НӨАТ-ын хувь тэнцүүлэн хасах хийх зохицуулалтын хүрээнд ирүүлсэн санал

4.НӨАТ-ын худалдан авалтын хувь тэнцүүлэн хасалт хийх зохицуулалтыг хасах /14.1.5/

 Хуулах

3,556 хариулт



Дээрх графикаас үзвэл цахимаар судалгаанд хамрагдсан 3556 оролцогчийн 68.3% нь НӨАТ-ын худалдан авалтын хувь тэнцүүлэн хасалт хийх зохицуулалтыг хасах санал гаргасан. Иймд, барилга, байгууламж болон тоног төхөөрөмжийн төлсөн НӨАТ-ыг хувь тэнцүүлэн хасах зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай.

### 3.2. “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

#### 3.2.1.Хэлэлцүүлгээс ирүүлсэн санал

1. УИХ-ын ажлын хэсэг - Нэгдсэн хэлэлцүүлэг 4 удаа<sup>21</sup>
  - a. 1 дүгээр сарын 28-ны өдөр 09-12 цагийн хооронд ААНОАТ-ын хуулиар
  - b. 1 дүгээр сарын 28-ны өдөр 14-17 цагийн хооронд ААНОАТ-ын хуулиар
  - c. 1 дүгээр сарын 30-ны өдөр 09-12 цагийн хооронд НӨАТ-ын хуулиар
  - d. 1 дүгээр сарын 30-ны өдөр 14-17 цагийн хооронд ХХОАТ-ын хуулиар
2. Татварын ерөнхий газар - Нэгдсэн хэлэлцүүлэг 4 удаа
  - a. 1 дүгээр сарын 20-ны өдөр 15-17 цагийн хооронд Мэргэжлийн холбоод, тэдгээрийн гишүүд, татвар төлөгч, сонирхогч бусад этгээд
  - b. 1 дүгээр сарын 23-ны өдөр 14-16 цагийн хооронд Хүнс, хөдөө аж ахуйн салбар, Уул уурхайн бус экспортлогчдын төлөөлөл, татвар төлөгч, сонирхогч бусад этгээд
  - c. 1 дүгээр сарын 27-ны өдөр 14-16 цагийн хооронд Барилга болон уул уурхайн салбарын төлөөлөл, татвар төлөгч, сонирхогч бусад этгээд
  - d. 1 дүгээр сарын 30-ны өдөр 14-16 цагийн хооронд Аялал жуулчлал болон тээврийн салбарын төлөөлөл, татвар төлөгч, сонирхогч бусад этгээд<sup>22</sup>
  - e. Мэргэжлийн холбоод, тэдгээрийн гишүүд, сонирхогч бусад этгээд
3. Нийслэл, дүүрэг, аймгуудад 2 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар нийт 187 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулсан.
4. Хэлэлцүүлэгт гарсан саналуудаас гадна МХАҮТ, МХАҮТ-ын УБ танхим, ММНБИ, MCS групп зэрэг мэргэжлийн холбоо болон томоохон групп компаниуд хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд саналаа ирүүлсэн.

Эдгээрээс хамгийн олон давтамжтай ирүүлсэн саналыг хүснэгтээр оруулж байна.

Хүснэгт 13. “Иргэд олон нийтээс НӨАТ холбогдуулан олон давтамжтай ирүүлсэн саналын нэгтгэл”

1. Хуулийн нэр томъёотой холбоотой санал		
№	Өөрчлөх санал	Шалтгаан
1.1.	14.1.4-д “иргэн, эсхүл хувь хүн” гэж нэмэх	<ul style="list-style-type: none"><li>14.1.4.заалтаас “иргэн” гэсэн зохицуулалтыг хассан нь хувь хүнээс худалдан авсан тохиолдолд НӨАТ-ын хасалт хийх боломжгүй болгож байна.</li></ul>
1.2.	8.1-д “Албан татварыг ногдуулахдаа дараах зарчмыг баримтална” гэж өөрчлөх	<ul style="list-style-type: none"><li>8.1-д журам гэхээр аль нэг эрх бүхий этгээд боловсруулсан гэх агуулгыг илэрхийлдэг.</li></ul>
1.3.	Бараа гэсэн тодорхойлолтыг эргэж харах	<ul style="list-style-type: none"><li>“Бараа” гэж мөнгөн хөрөнгөнөөс бусад бүх төрлийн хөрөнгийг хэт өргөн, ерөнхий агуулгатай тул татвар төлөгчийн хуулийн хамрах хүрээнд хамаарахгүй ажил гүйлгээнд</li></ul>

<sup>21</sup> Хавсралт 1-ийг үзнэ үү.

<sup>22</sup> Хавсралт 2-ыг үзнэ үү.

		НӨАТ ногдуулах эрсдэл үүсгэдэг.
1.4.	Борлуулалт гэсэн тодорхойлолтыг эргэж харах	<ul style="list-style-type: none"> <li>• "Борлуулалт" гэж барааг бусдын өмчлөлд шилжүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхийг;</li> <li>• Эцсийн эзэмшигч хүртэлх үргэлжилсэн хэлхээ холбоонд хамаарах хуулийн этгээд хооронд хувьцаа шилжүүлэх, нэгдэх, нийлэх, тусгаарлах, шинэ хуулийн этгээд үүсгэн байгуулах хэлбэрээр хэлхээ холбоо доторх хувьцаа, хувь оролцоонд хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийсэн, мөн ийм байдлаар саналын эрхийн бүтцийг өөрчилсөн тохиолдолд - борлуулалт биш юм. Иймд хуульд шинээр тодорхойлох шаардлагатай.</li> </ul>
1.5.	"Ажиллагсдын хэрэгцээ" гэсэн ойлголтыг тодорхой болгох шаардлага практикт үүсээд байна.	<ul style="list-style-type: none"> <li>• "Ажиллагчдын хэрэгцээ" гэж нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчийн эрхэлж байгаа үйлдвэрлэл, үйлчилгээтэй болон тухайн ажилтны ажил үүргээ гүйцэтгэхтэй шууд холбоогүй ажиллагчдад хувьд нь зориулан худалдан авч олгосон бараа, үзүүлсэн үйлчилгээ тус тус хамаарна. Иймд худалдан авалтын НӨАТ-г хасах нь зөв юм.</li> </ul>
2. НӨАТ -ын хувь хэмжээтэй холбоотой санал		
2.1.	"НӨАТ-ын хувь хэмжээг бууруулах, 5% болгож бууруулах"	<ul style="list-style-type: none"> <li>• "5% болсноор ААН-д дарамт багасна.</li> <li>• НӨАТ-ын баримт олгохгүй байх сонирхол багасна.</li> <li>• Бууруулах боломжгүй бол шатлалтай болгох"</li> <li>• "НӨАТ суутган төлөгчийн босгогүй болгож, татварын хувь хэмжээг 5% болгон бууруулах нь бодит байдалтай уялдсан, далд эдийн засгийг ил болгох, татварын суурийг нэмэгдүүлэх, зэрэг чухал ач холбогдолтой оновчтой зохицуулалт болохоор байна.</li> <li>• Татварын хувь хэмжээг бууруулан бааз суурийг өргөтгөснөөр бодитой үр дүн гардгийг дараах баримтуудаас тодорхой харж болно. 2007 онд НӨАТ-ыг 15 хувь байсныг 10 хувь болгон бууруулснаар НӨАТ-ын орлого 2002-2006 онд өмнөх оноос дунджаар 16.8% өсдөг байсан бол 2007 онд 38.9% болж өссөн. Түүнчлэн НӨАТ төлөгчийн тоо жилд дунджаар 14.4% өсдөг байсан бол 31.4% болж өссөн байна. "</li> </ul>

2.2.	Ялгавартай тогтоох эсвэл шатлалтай болгох	<ul style="list-style-type: none"> <li>• "Гадаад болон дотоодын компаниудад ялгавартай тогтоох хэрэгтэй</li> <li>• Бууруулах боломжгүй бол шатлалтай болгох -"</li> <li>• Орон нутаг болон Улаанбаатар гэсэн ялгавартай тогтоох</li> <li>• НӨАТ-ын хувь хэмжээг манай улсад 10% болон 0% гэсэн хоёрхон тоо байдаг, бусад улс оронд салбарын бодлогоос хамаараад хувь хэмжээг янз бүрээр тогтоодог болох Уул уурхай дээр илүү өндөр байх хэрэгтэй, барилга, хүнс, оёдол гэх зэрэг нь бага байх хэрэгтэй</li> </ul>
2.3.	НӨАТ-ын хувь хэмжээг 10% хэвээр мөрдөх	<ul style="list-style-type: none"> <li>• "НӨАТ-ын хувийг өөрчлөхөөс илүүтэй тэгш шударга төлдөг тогтолцоог бий болгомоор байна;</li> <li>• НӨАТ хэд байхаасаа илүүтэйгээр НӨАТ-ын буцаан олголт эдийн засгийн шударга байдлыг бий болгоход асар хүчтэй нөлөөлөх байх гэж бодож байна. Бүх 3 сая гаруй хүнийг татварын орчинд хамруулах хэрэгтэй;"</li> </ul>
2.4.	0 хувь хэрэглэх	<ul style="list-style-type: none"> <li>• Кашмер холдинг - нийт борлуулалтын 60% жуулчид авдаг. Экспорт гэж үзээд "0" хувь ногдуулах нь зүйтэй.</li> <li>• Хөдөө аж ахуйн салбарын бүтээгдэхүүнийг зөвхөн эхний шатан дээр НӨАТ-с чөлөөлж байгаа нь өрөөсгөл юм. Тиймээс бодлогоор дэмжих салбар, үйл ажиллагааг эцсийн хэрэглэгч хүртэлх бүх шатанд НӨАТ -ийг 0%-р ногдуулдаг байх</li> </ul>
3. НӨАТ -ын урашуулалтай холбоотой санал		
3.1.	И-баримтын сугалааны урамшууллын дүн өндөр байна. Бага урамшууллаар олон хүнийг хамруулмаар байна.	<ul style="list-style-type: none"> <li>• И баримт сугалааны дүн дэндүү том байгаа юм.</li> <li>• Сугалаа заавал тийм том байх албагүй маш олон хүнийг жигд хамруулсан байх ёстой.</li> </ul>
3.2.	Буцаан олголтын хувь хэмжээг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• "НӨАТ-ын буцаан олголтын 2 хувийг 4-5 хувь болгох, сугалааг болиулах</li> <li>• НӨАТ-ын буцаан олголтыг 50, 60, 70 хувь болгох эсвэл аль салбарт татвар төлдөггүй</li> </ul>

		<p>бизнес байгааг илрүүлэх зорилгоор 100 хувь ч байж болно;</p> <ul style="list-style-type: none"> <li>Иргэн НӨАТ-ын 20 хувийг буцаан авдаг жишигтэй адилаар төр өөрийнхөө ажил үйлчилгээний НӨАТ-ыг 100 хувь буцааж авснаар төсвийн хөрөнгө оруулалт, төсвөөр дамжиж буй тендер концессын бүх санхүүгийн бүртгэл НӨАТ-ын баримттайгаа 100 хувь бүртгэгдэнэ"</li> </ul>
4. НӨАТ - ын хасалт хийхтэй холбоотой санал		
4.1.	14.6.2.хувийн болон ажиллагсдын хэрэгцээнд зориулан худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>"Хүний нөөцийн ийм хомсдолтой үед хүмүүсээ идэвхжүүлэх, урамшуулах, хөгжүүлэх зардал үнэхээр өсгөхөөс аргагүй байгаа.</li> <li>Ажиллагсадтай холбоотой гарч байгаа зардлыг хасагдах зардалд оруулж өгөх нь зүйтэй.</li> <li>Эсвэл хязгаар тавьж өгөөд орлогын тэдэн хувиар нь хязгаарлаж болно. "</li> </ul>
4.2.	Аудитын үйлчилгээ ихэнх зардал цалингийн зардал - НӨАТ-ын хасалт хийх боломжгүй байдаг тул өрөнд ордог - Тооцож хасдаг болгох буюу НӨАТ-ын хасагдах зардалд оруулах.	<ul style="list-style-type: none"> <li>"Дийлэнх зардал нь Хүний нөөц, цалин хөлснөөс бүрддэг Зөвлөх үйлчилгээний салбарын ААН-үүдийн орлогод НӨАТ ногддог. Гэтэл ихэнх зардал нь Цалин хөлс учраас хасуулах НӨАТ байдаггүй"</li> </ul>
4.3.	ОУ-ын тээврийн үйлчилгээ эрхэлдэг ААН- хилийн гадна гарсан зардлууд НӨАТ-ын баримтгүй шалтгаанаар хасагдах боломжгүй болдог. Иймд НӨАТ-аас хасагдах зардалд оруулах.	<ul style="list-style-type: none"> <li>Орлогыг бүрэн бүртгэсэн боловч Хилийн гадны гарсан зардлуудыг НӨАТ-ын баримтгүй шалтгаанаар хасагдах зардал болгохгүй байна.</li> </ul>
4.4.	"Суудлын автомашин, түүний эд анги, сэлбэгт төлсөн НӨАТ-ыг хасахгүй байгаа. Энэ нь хэт ерөнхий байна. Тухайлбал; Хүргэлтийн үйлчилгээ бүхий худалдаа үйлчилгээний бизнесүүдэд суудлын зориулалттай авто машин ашигладаг. "	<ul style="list-style-type: none"> <li>Компани аж ахуйн үйл ажиллагааны зорилгоор ашигладаг тээврийн хэрэгсэл нь суудлын автомашин байгаа тохиолдолд түүний НӨАТ-н хасалтыг тооцохгүй байгаа нь татвар төлөгчдөд бизнесийн онцлогийг харгалзаж үзээгүй хяналтыг хялбарчлах зорилготой хэт ерөнхийлсэн заалт.</li> </ul>
4.5.	14.6.4. импортод төлсөн НӨАТ-ийг үйл ажиллагаатай хамааралтай, хамааралгүй гэж ялгаж үздэгийг болих	<ul style="list-style-type: none"> <li>"14.6.4.тайлант хугацааны албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээтэй хамааралгүй импортоор оруулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Татвар төлөгчдийн бизнесийн онцлогийг харгалзаж үзээгүй хяналтыг хялбарчлах зорилготой хэт ерөнхийлсөн заалт"</li> </ul>
5. Оршин суугч бус этгээдээс суутгасан НӨАТ-тай холбоотой санал		
5.1.	Оршин суугч бус этгээдээс суутгасан НӨАТ-ыг хасч тооцдог болвол буурах татварын орлогын тооцоолол /тооцоо хийгээд өгөх нь зүйтэй байх. /Зарчим талаасаа reverse charge байж болох асуудал/	<ul style="list-style-type: none"> <li>• "Зөвлөх үйлчилгээ, ИТ үйлчилгээ гадаадаас авахад биет зүйлд гаалийн бүрдүүлэлт хийнэ гэх зэргээр зөрчилддөг.</li> <li>• Гадаадад хийгдсэн ХА -д хасалт хийж чадахгүй байна</li> <li>• ОУ-ын тээврийн үйлчилгээ эрхэлдэг ААН-хилийн гадна авсан үйлчилгээ нь асуудал болдог. Татварын үүрэг нь ААН-д үлдэж байна."</li> </ul>
5.2.	Худалдах, түүнчлэн үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар Оршин суугч бус этгээдээс худалдан авч импортоор оруулсан бараа болон ажил, үйлчилгээнд төлсөн НӨАТ-г хасалт хийх;	<ul style="list-style-type: none"> <li>• "[НӨАТх-7.1.2, 7.2.5. 14.1.2]</li> <li>• Монгол Улсын аж ахуйн нэгжүүд Гадаад Улсаас авсан ажил, үйлчилгээнд төлсөн дүнгээс НӨАТ-г суутган (нэмж) төлөх үүрэгтэй байдаг бөгөөд НӨАТ-н хасалт хийх эрхгүй байдаг</li> <li>• Оршин суугч бус давхар даатгагчаас авсан давхар даатгалын үйлчилгээнд гаалийн бүрдүүлэлт хийх боломжгүйгээс болж НӨАТ-ын зардал тус бүр нэмэгдэхээр даатгагчид ирэх татварын дарамт 10%-30% болж байна.</li> <li>• Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 16.1.2.оршин суугч бус этгээдээс энэ хуулийн 7.2.5-д заасан гаалийн бүрдүүлэлт хийлгээгүй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа үнийн дүнгээс албан татварыг суутган авч төсөвт төлнө гэх заалт зөрчилдөж байна"</li> </ul>
6. НӨАТ-ыг мөнгөн сууриар ногдуулахтай холбоотой санал		
6.1.	НӨАТ-ын мөнгөн суурьтай болгох	<ul style="list-style-type: none"> <li>• Барилгын салбарт бартерын гүйлгээ их байдаг. Давхар татвар төлөх болоод байна.</li> <li>• "Бараа, ажил үйлчилгээг бэлэн бусаар борлуулсан бол борлуулалтын гэрээнд заасан төлбөрийн хуваарийг үндэслэн тухай бүрд</li> <li>• Авлага - Хувь дансаар мөнгөө авах эрсдэл</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Авлага төлөгдөхгүй байх эрсдэл үүснэ.</li> <li>• Авлага - Авлагын бичиг</li> <li>• Гэрээ байхгүй - боломжгүй"</li> </ul>
6.2.	Албан татвар ногдуулах хугацааг орлого хүлээн зөвшөөрөх хугацаатай уялдуулан, мөнгөн суурьтай болгон өөрчлөх:	<ul style="list-style-type: none"> <li>• "Өнөөгийн байдлаар борлуулалтад ногдуулах НӨАТ-ыг аккруэл сууриар, худалдан авалтад ногдох НӨАТ-ыг мөнгөн сууриар тооцож байгаа нь НББ-ын стандартаас зөрүүтэйгээр тайлагнах, мөнгө/орлого/ нь орж ирээгүй борлуулалтад урьдчилж татвар төлөх, тухайн татварын зардлыг санхүүжүүлэх хүүтэй эх үүсвэр ашиглах зэрэг бэрхшээл, бизнесийн зардлыг нэмэгдүүлэх хүндрэл үүсгэж байна</li> <li>• НӨАТ-ыг аккруэль сууриар бүртгэж, тайлагнаж байгаа нь аж ахуйн нэгж байгууллагуудад маш хэмжээний татварын өр бий болгож байна. Орлого нь орж ирээгүй байхад баахан татварын өртэй болчихдог, татварт төлөх мөнгө нь бэлэн байхгүй, гэтэл Татварын алба татвараа төлөөгүй гээд дансыг нь хаачихдаг нь маш шударга бус байна. НӨАТ-ын борлуулалтыг мөнгө орж ирсэн үед нь бүртгэдэг, тайлагнадаг байхгүй бол энэ нь маш их асуудлыг үүсгэж байна.</li> <li>• 14.6.6 Өмнөх тайлант хугацааны албан татвар ногдох бараа, ажил, үйлчилгээтэй хамааралтай худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлбөр нь хийгдээгүйгээс хойшлуулсан НӨАТ-ын хасалт энэ хуулийн - 14.6.4 заалтад хамаарахгүй.</li> <li>• борлуулсан бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлогыг хүлээн авсан өдрөөр албан татвар ногдуулах хугацааг тооцох" заалтын хувьд Татварын байцаагч нар ""Борлуулалтын орлого"", ""Урьдчилж орсон орлого/төлбөр"" гэсэн хоёр өөр ойлголтыг нэг мэтээр тайлбарлаж бодитоор борлуулаагүй байгаа бараа, үйлчилгээний төлбөрт НӨАТ ногдуулахыг шаарддаг. "</li> </ul>
7. НӨАТ-ын баримт өгөхгүй байгаатай холбоотой санал		
7.1.	"НӨАТ-ын баримт өгөхгүй байна. НӨАТ-ын босготой холбоотойгоор суутган төлөгчөөр бүртгүүлэхгүй байх сонирхол их байна"	<ul style="list-style-type: none"> <li>• "НӨАТ-тай авах уу НӨАТ-гүй авах уу гэж асуудаг.</li> <li>• Энэ нь болдог гэсэн ойлголтыг бий болгож байна.</li> <li>• Барс зах, Нарантуул зах, 100 айл, Өгөөмөр</li> </ul>

		<p>зах -баримт өгөхгүй байна</p> <ul style="list-style-type: none"> <li>• Малчдаас ХА хийсэн үед зардлын баримтаа бүрдүүлж чаддаггүй. Үүний хариуцлагыг худалдан авалт хийсэн ААН хүлээж байна.</li> <li>• Жижиг бизнес эрхлэгч баримт өгөхгүй болохлоор тэр баримтыг компаниуд тайлан дээрээ тусгахын тулд нэмэлт зардлаа гаргаж байна</li> <li>• Төрийн байгууллага НӨАТ-ын баримт олгодог, шивдэг баймаар байна</li> <li>• Барилга - Хувь хүн бригадуудаар ажил гүйцэтгүүлдэг. Энэ тохиолдолд НӨАТ-ын баримт олгодоггүйгээс хасагдах зардлаа тусгаж чаддаггүй -1.27-6"</li> </ul>
7.2.	Импортын барааны хувьд гааль дээр төлсөн зардлаа нотлож чалахгүйгээс болоод борлуулалтад баримт өгөх дургүй.	<ul style="list-style-type: none"> <li>• "Импортын бараа - Гаальтай машин</li> <li>• Цахим арилжаа эрхлэгчид - түүвэр ачаа, карго ачаа</li> <li>• ХА-гч бүх татвараа төлдөг боловч төлсөн мөнгөндөө төлбөрийн баримт авч чаддаггүй. Үүнээс болоод хасагдах зардал байхгүй тул борлуулалтад НӨАТ-ын баримт өгөх дургүй байдаг"</li> </ul>
7.3.	Цахим худалдан авалтуудад НӨАТ баримт өгөхгүй байна.	<ul style="list-style-type: none"> <li>• "Цахим худалдан авалтад НӨАТ баримт өгөхгүй байгаа, үүнийг хянаж зохицуулах, их хэмжээний борлуулалт НӨАТ гүй явж байна</li> <li>• ААН-үүд зардлаа бүрэн бүртгүүлж, хасаж чадахгүй байна"</li> </ul>
8. Бусад санал		
8.1.	НӨАТ суутган төлөгчийг бүртгэх, бүртгэлээс хасах нөхцөл, шалгуурыг тодорхой болгох	<ul style="list-style-type: none"> <li>• "Барилгын салбар 3-4 жил үргэлжилдэг онцлогтой.</li> <li>• Манай компанийн хувьд өөрсдийн хөрөнгөөр ажлаа гүйцэтгэж хүлээлгэн өгөөд орлогоо авахаар гэрээтэй байгаа бөгөөд НӨАТ төлөгчөөр бүртгүүлээд худалдан авалт хийгээд зардлын баримтаа хуримтлуулаад явж байсан. Гэтэл НӨАТСТ-ийн бүртгэлээс хасчихсан. Гарсан бүх зардалд төлсөн НӨАТ-аа хасуулж чадахгүй болсон.</li> <li>• Шинээр байгуулагдаж байгаа компани хөрөнгө худалдан авсны дараа борлуулалтын орлого орж НӨАТ төлөгч болдог.</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>Гэтэл хөрөнгө худалдан авах үед төлсөн НӨАТ нь НӨАТ төлөгч болохоос өмнө төлөгдсөн байдаг тул ашиглах боломжгүй болдог. Иймд НӨАТ төлөгч болохоос өмнө худалдан авсан хөрөнгөд ногдох НӨАТ ыг НӨАТ төлөгч болсны дараа тооцон суутгах боломж шийдэл хэрэгтэй байна."</li> </ul>
8.2.	Импортын бараанд ногдуулсан НӨАТ-ыг тодорхой хугацаанд хойшлуулдаг болох	
8.3.	НӨАТ тухай хуулийн хариуцлагын тогтолцооны давхардал болон Зөрчлийн хуультай давхцаж буйг дахин нягтлах	
8.4.	Хууль дагасан журмууд хууль батлагдсанаас хойш маш удаан хугацааны дараа гардаг. Энэ байдлыг болиулж хуультайгаа хамт гаргадаг баймаар байна.	
8.5.	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллыг шинэчлэх	
8.6.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний орлогыг НӨАТ-аас чөлөөлөх	
8.7.	Тендерийн шаардлагад НӨАТ-ын өрийг харгалзан үздэгийг болих	
8.8.	Гааль дээр НӨАТ төлдгийг болих - МХАҮТ	
8.9.	Төлбөрийн баримт олгоогүй үед хариуцлагын тогтолцоог хялбаршуулж, баримтын дүнтэй уялдуулан хариуцлага тооцох	
8.10.	НӨАТ-ын тайланг улирлаар гаргадаг болох	
8.11.	Томоохон ААН-д туслан гүйцэтгэгч авах буюу жижиг, бичил бизнес эрхлэгчийг НӨАТ суутган төлөгчөөр бүртгүүлэхийг шаардах	
8.12.	Гаалийн татвар нь импортын бараанд ногдож, худалдан авалтын өртөгт шингэдэг. Гаалийн татвар нэмсэн дүнгээс НӨАТ авч байгааг зогсоох хэрэгтэй	
8.13.	Татварын илүү төлөлтийг суутган төлөгчийн хүсэлтээр хууль тогтоомжийн дагуу төсөвт төлөх бусад төрлийн татварын төлбөрт шууд шилжүүлэн тооцдог болгох	
8.14.	ААНӨАТ-н хуулийн 30 дугаар заалтаар хувьцаа борлуулах замаар эрх борлуулсан гэж тооцогдох тохиолдолд эрх борлуулалтын дүнг НӨАТ-с чөлөөлөх	

### 3.2.2.Цахимаар ирүүлсэн санал<sup>23</sup>

Татварын хуулийн шинэчлэл нэртэй цахим санал асуулгыг дүн 2025 оны 1 дүгээр сарны 20-ны өдрөөс мөн оны 2 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл авсан бөгөөд энэхүү дүн нь 2 дугаар сарын 10-ны өдрийн 17 цагаар тасалбар болгон авсан дүн болно. Мөн практик хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн заалтад холбогдох хэсэгт цахимаар ирүүлсэн саналыг хавсаргасан болно.

График 5. "Татварын хуулийн шинэчлэл" судалгаагаар НӨАТ-ын хувь хэмжээ, зохицуулалттай холбоотой ирүүлсэн санал




График 5-аас НӨАТ-ын хувь хэмжээ зохицуулалттай холбоотой саналыг тусгасан бөгөөд нийт 3556 иргэн, хуулийн этгээд тус судалгаанд хамрагдсан байна. Энэхүү судалгаанд хамрагдсан иргэн, хуулийн этгээдийн 64.2% хувь нь НӨАТ-ын хувь хэмжээг 5 хувь болгох саналыг 18.6% хувь нь НӨАТ-ын хувь хэмжээг шаталсан байдлаар авах саналыг гаргажээ.

<sup>23</sup> "Татварын хуулийн шинэчлэл" цахим санал асуулга, [https://docs.google.com/forms/d/1KiX2OgXrBJ\\_bSPaOrFrw7TEOXc344YINSYOgkjhsccds/viewanalytics?pli=1&pli=1](https://docs.google.com/forms/d/1KiX2OgXrBJ_bSPaOrFrw7TEOXc344YINSYOgkjhsccds/viewanalytics?pli=1&pli=1)

## ДҮГНЭЛТ, САНАЛ

НӨАТТХ-ийн хэрэгжилт, өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудалд дүн шинжилгээ хийх, тэдгээрт үндэслэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, зөвлөмж боловсруулах зорилгоор тус хуульд хэсэгчлэн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн бөгөөд дараах дүгнэлтийг хийж байна.

- 2015 оны НӨАТТХ-ийн хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д Албан татвар төлөгчийн үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба түүнээс дээш төгрөгт хүрч, албан татвар ногдуулан суутган төлөгч байна гэж заасан. Энэхүү босгыг тооцохдоо олон улсын жишиг аргачлалын баримталсан бөгөөд тухайн үеийн /2015 оны/ 50 сая төгрөгийг өсгөх шаардлага үүссэн. Мөн НӨАТ-ын хэлэлцүүлэгт оролцсон иргэн, хуулийн этгээдээс НӨАТ-ын босгыг нэмэгдүүлэх саналыг олонтоо ирүүлсэн. Энэ нь практикт босго үнийг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг илэрхийлж байна. Иймд, НӨАТТХ-ийн босго дүн болох 50 сая төгрөгийг 400 сая төгрөг болгож нэмэгдүүлэх, өнөөгийн үнэ цэнэ, татварын үр ашигт байдлыг харгалзан үзэх шаардлага үүсч байна.
- НӨАТТХ-ийн 8 дугаар зүйл “Албан татвар ногдуулах” – ийн 8.1.1-д “бараа, ажил, үйлчилгээг импортоор оруулсан, экспортод гаргасан, түүнчлэн **борлуулсан бол** тухай бүрд”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-д “10.2.2.бараа, ажил, үйлчилгээг **“борлуулсан”** өдрөөс НӨАТ ногдуулахаар хуульчилсан. Энэ нь ТӨХ болон НӨАТТХ-ийн ерөнхий заалттай зөрчилдөж байна. Энэ нь бараагаа шууд мөнгөөр борлуулсан буюу борлуулсан даруйд төлбөр тооцоо хийгдсэн тохиолдолд ямар нэгэн хүндрэл байхгүй. Харин борлуулсан барааны төлбөрийг тодорхой хугацааны дараа авах нөхцөл (энэ нь бизнесийн хэвийн нөхцөлд маш түгээмэл байдаг нөхцөл) - өөр борлуулалт хийгдсэн тохиолдолд гажуудал үүсгэж байна. Учир нь төлбөр тооцоо хийгдээгүй, орлого нь мөнгөөр орж ирээгүй байхад, борлуулалт хийгдсэн гэдгээр татвар нь ногдуулаад татварын өртэй болчихдог, татварт төлөх мөнгө нь бэлэн байхгүй, өрөө төлж чадахгүй байснаас болж дансаа хаалгадаг, тендерийн гэх мэт шаардлагаар тодорхойлолт авахад татварын өртэй гэж гардаг зэрэг олон хүндрэл үүсдэг байна. Өөрөөр хэлбэл, НӨАТТХ-иар зардлыг хүлээн зөвшөөрөхдөө цахим системээс хэвлэгдсэн төлбөрийн баримтыг үндэслэх бөгөөд энэ нь төлбөр тооцоо хийгдсэн үед буюу зардлыг мөнгөөр төлөгдсөн үед /мөнгөн сууриар/ хүлээн зөвшөөрдөг. Гэтэл орлогын хувьд төлбөр тооцоо хийгдсэн эсэхээс үл шалтгаалан хуулийн 8.1.1-д заасны дагуу бараа, ажил, үйлчилгээг борлуулсан бол тухай бүрд нь буюу барааг бусдын өмчлөлд шилжүүлсэн, ажил үйлчилгээг үзүүлсэн үед нь /аккруэль суурь/ хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Иймд, НӨАТ-ыг ногдуулахдаа аккруэль суурь, хасалт хийхдээ мөнгөн суурь ашиглаж байгаа нь бизнес эрхлэгч этгээдэд хүндрэл үүсгэж байна. Энэ санал иргэдээс олон нийтийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлэг, албан бичиг, судалгаанд дурдагдаж байна. Тодруулбал, НӨАТ ногдуулахдаа НӨАТТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “борлуулсан тухай бүрд”, 10 дугаар зүйлийн 10.2.2-д “борлуулж”, 14 дүгээр зүйлийн 14.3-д “бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилсэн үзүүлсэн тухай бүрд” гэж заасныг баримталдаг. Иймд, эдгээр утга нь цаг хугацааны хувьд ялгаатай ойлголт гэдгийг харгалзах, өөрчлөх шаардлагатай байна.
- Монгол Улсад нийт 28 төрлийн бараа, 19 төрлийн үйлчилгээ уг татвараас чөлөөлөгдөх зохицуулалттай байна. Мөн тодорхой салбарт, тодорхой хугацаатайгаар Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсөн 40 гаруй хууль үйлчилж байна. Үйлдвэрлэлийн дамжлаг буюу гинжин хэлхээний аль нэгийг нь НӨАТ-

аас чөлөөлж буй нь тус хуулийн хэрэгжилт, дараагийн шатны дамжлагад хүндрэл үүсгэж байна. Харин мөн хуулийн 13.10 энэ дээрх бүтээгдэхүүний дамжуулан борлуулагч нарт хамаарахгүй гэж заасан. Энэ нь тухайн бүтээгдэхүүнийг худалдан борлуулагч этгээдэд хүндрэл үүсгэж бүтээгдэхүүний үнийг өсгөхөд нөлөөлж байна. Мөн НӨАТ-ын хэлэлцүүлэгт оролцсон иргэн, хуулийн этгээдээс НӨАТ-ын чөлөөлөлтийн асуудлыг шийдвэрлэх саналыг олонтоо ирүүлсэн. Энэ нь практикт НӨАТ-ын чөлөөлөлтийг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага байгааг илэрхийлж байна. Иймд, НӨАТтХ-ийн 13 дугаар зүйл буюу Албан татвараас чөлөөлөх эрх зүйн орчныг сайжруулах, одоогийн зохицуулалтыг өөрчлөх хэрэгцээ, шаардлага үүссэн.

- Барилга, байгууламж хувьд 10 жил, тоног төхөөрөмжийн хувьд 5 жилээр хувь тэнцүүлсэн хасалтыг хийхээр хуульчилсан. Энэ нь бизнес эрхлэгч талд өнөөдрийн худалдаж авсан хөрөнгийг буцаан олголтыг удаан хугацаанд бага дүнгээр хасалт хийх сөрөг нөхцөл байдлыг, Татварын албанд практикт уг заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлийг тус тус бий болгож байна. Иймд, барилга, байгууламж болон тоног төхөөрөмжийн төлсөн НӨАТ-ыг хувь тэнцүүлэх хасах зохицуулалтыг өөрчлөх шаардлагатай.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

### Сурах бичиг, гарын авлага

1. ОУВС, Торонтогийн Их сургуулийн хамтарсан судлаачид 2004 онд Майкл Кийн, Жак Минзийн “НӨАТ-ын босгын хэмжээг оновчтой тогтоох загвар”,
2. Хууль зүй, дотоод хэргийн яам, Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (GIZ)-ийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчинг баталгаажуулах төсөл”, Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага, Уб, 2016.

### Хууль, эрх зүйн акт

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Уб, 2015, <https://legalinfo.mn/mn/detail/11227>
2. Монгол Улсын Засгийн Газрын Тогтоол, Дугаар 59, Аргачлал батлах тухай, 2016, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=207338&showType=1>
3. Татварын Ерөнхий хууль, Уб, 2019, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14403>
4. Монгол Улсын Их Хурлын Тогтоол, Дугаар 21, Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны Үйл ажиллагааны хөтөлбөр, Уб, 2024, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17141368388631&showType=1>
5. Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=206987>

### Цахим эх сурвалж

1. Татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, Tais.mta.mn
2. “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж байна, <https://www.parliament.mn/nn/74036>
3. “Татварын хуулийн шинэчлэл” цахим санал асуулга, [https://docs.google.com/forms/d/1KiX2OgXrBJ\\_bSPaOrFrw7TEOXc344YINSYOqjihscds/view\\_analytics?pli=1&pli=1](https://docs.google.com/forms/d/1KiX2OgXrBJ_bSPaOrFrw7TEOXc344YINSYOqjihscds/view_analytics?pli=1&pli=1)

-

## ХАВСРАЛТ

Хавсралт 1. Монгол Улсын Татварын тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал, шинэчлэх хэрэгцээ шаардлага, цуврал хэлэлцүүлэг.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

### "МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ТОГТОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШИНЭЧЛЭХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА"

**ЦУВРАЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ**

**ЗОХИОН БАЙГУУЛАГЧ**

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО**  
УИХ-ын даргын 2024 оны 292 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг

- 1**  
✓ "Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль"  
🕒 01-р сарын 28-ны өдөр хэлэлцүүлэг 9-12 цаг  
👤 "Жанжин Д.Сүхбаатар" танхимд
- 2**  
✓ "Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль"  
🕒 01-р сарын 28-ны өдөр хэлэлцүүлэг 14-17 цаг  
👤 "Жанжин Д.Сүхбаатар" танхимд
- 3**  
✓ "Нэмэгдсэн өртөгийн албан татварын тухай хууль"  
🕒 01-р сарын 30-ны өдөр хэлэлцүүлэг 09-12 цаг  
👤 "Их Эзэн Чингис хаан" танхимд
- 4**  
✓ "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"  
🕒 01-р сарын 30-ны өдөр хэлэлцүүлэг 14-17 цаг  
👤 "Их Эзэн Чингис хаан" танхимд

**ОРОЛЦОГЧ ТАЛУУД**

- МҮХАҮТ, Мэргэжлийн холбоод болон Олон улсын байгууллага, татвар төлөгч, сонирхогч бусад этгээд
- Дунд, жижиг, бичил бизнес эрхлэгч аж ахуй нэгж, сонирхогч бусад этгээд
- Татвар төлөгч иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөл, эрдэмтэн, судлаач, сонирхогч бусад этгээд
- Татвар төлөгч иргэн, аж ахуй нэгжийн төлөөлөл, эрдэмтэн, судлаач, сонирхогч бусад этгээд

Иргэн, аж ахуй нэгж байгууллага татварын багц хуулийн хэрэгжилтэд тулгарч ауй асуудал, санал гомдлоо дараах QR нэвтрэн өгнө үү

Хэлэлцүүлэгт оролцох иргэн, аж ахуй нэгж дараах QR болон 262528 ДТЛААРЫН УТСААР бүртгүүлнэ үү




## “ТАТВАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ШИНЭЧЛЭЛ” НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ХӨТӨЛБӨР

Хугацаа: 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 2 дугаар сарын 06-ны өдрийг дуустал  
Хянаа: Татварын ерөнхий газрын 8 давхарт “Татвар төлөгчийн танхим”

### Татварын ерөнхий газар

<p><b>1</b> 2025.01.20 ☉ 15:00-17:00</p> <p>Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт Татварын мэргэшсэн зөвлөхийн вийгэмлэг Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт Бусад мэргэжлийн мэдлэг, гичүүд, нягтлан бодогчид, сонирхогч бусад этгээд</p>	<p><b>2</b> 2025.01.23 ☉ 14:00-16:00</p> <p>Хүнс, хөдөө аж ахуйн салбарын татвар төлөгчид Уул уурхайн бус экспортологчид, сонирхогч бусад этгээд</p>
<p><b>3</b> 2025.01.27 ☉ 14:00-16:00</p> <p>Барилга болон уул уурхайн салбарын татвар төлөгчид, сонирхогч бусад этгээд</p>	<p><b>4</b> 2025.01.30 ☉ 14:00-16:00</p> <p>Авчлал жуулчлал болон тээврийн салбарын татвар төлөгчид, сонирхогч бусад этгээд</p>

### Нийслэл, дүүргийн татварын алба

Дунд, жижиг, бичил бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, татвар төлөгч иргэн болон сонирхогч бусад этгээдийг хамруулан **2025.01.22-ноос 29-ний өдрийн** хооронд зохион байгуулна.

### Аймгийн татварын газар

Дунд, жижиг, бичил бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, татвар төлөгч иргэн болон сонирхогч бусад этгээдийг хамруулан **2025.01.23-наас 30-ны өдрийн** хооронд зохион байгуулна.

### Ажлын хэсэг

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн шинэчилэл	2025.02.03
Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилэл	2025.02.04
Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн шинэчилэл	2025.02.05
Бусад татварын хуулийн шинэчилэл	2025.02.06



Татварын хууль тогтоомжийн шинэчлэлд саналгаа өгнө үү

☎ 75751288 - 304  
🌐 etax.mta.mn  
📍 Монголын Татварын алба